



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/671

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны
“Конвер” өрхийн эрүүл мэндийн төвийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 12 нэр төрлийн 5,838,850.99 /Таван сая найман зуун гучин найман мянга найман зуун тавин төгрөг ерэн есөн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны “Конвер” өрхийн эрүүл мэндийн төв /М.Мөнхжаргал/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 52,300.0 /тавин хоёр мянга гурван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 13 нэр төрлийн 4,514,955.0 /Дөрвөн сая таван зуун арван дөрвөн мянга есөн зуун тавин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, Удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны “Конвер” өрхийн эрүүл мэндийн төв /М.Мөнхжаргал/-д даалгасугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001493

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оныдугаар
 12сарын 11...өдрийн 1/141 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны "Конвер" ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХК-ын шийдвэр
1	Ус буцалгагч	12	1	24,420.00	24,420.00	24,420.00	-	татах
3	Товгортой цагираг	10	1	25,000.00	25,000.00	25,000.00	-	устгах
4	Ариутгалын бикс	19	4	196,231.25	784,925.00	784,925.00	-	татах
5	Хар сандал	19	7	156,478.57	1,095,349.99	1,095,349.99	-	татах
6	Төмөр саарал шкаф	19	1	157,383.00	157,383.00	157,383.00	-	татах
7	Кушетик	6	3	80,000.00	240,000.00	170,000.00	70,000.00	татах
ДҮН					2,327,077.99	2,257,077.99	70,000.00	
Тоног төхөөрөмж								
1	Офтальмоскоп	7	1	156,273.00	156,273.00	125,886.32	30,386.68	татах
2	Компьютер Dell	5	2	430,000.00	860,000.00	519,583.14	340,416.86	татах
3	Даралтын аппарат Rapasonik	8	1	850,000.00	850,000.00	850,000.00		татах
4	ЭКГ аппарат ECG901	10	1	1,360,000.00	1,360,000.00	1,360,000.00		татах
5	Хувилагч машин	19	1	310,500.00	310,500.00	310,500.00		татах
ДҮН					3,536,773.00	3,165,969.46	370,803.54	татах
Нийт дүн					5,863,850.99		440,803.54	
Үүнээс: Устгах хөрөнгийн дүн					25,000.00			
Татан төвл-х хөрөнгийн дүн					5,838,850.99			